



МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 26-ны өдөр

№01

Улаанбаатар хот

2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН ДҮГНЭЛТҮҮД, 2024 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2024 оны 03 сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын 01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Хавсралт №01-ээр, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүгнэлтийг Хавсралт №02-оор, Компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг Хавсралт №03-аар тус тус баталсугай.

2. Тайлант оны үйл ажиллагааны ололтоо бататган, эрхэм зорилго, зорилтоо биелүүлэхэд тодорхой бодлого чиглэл боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон компанийн удирдлагуудад даалгасугай.

3. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хийсэн Аудитын хорооны зөвлөмж, дүгнэлтийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг компанийн Санхүү, эдийн засгийн хэлтэст үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУН



МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 26-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ГИШҮҮДИЙН ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХЭМЖЭЭГ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь хэсэг, 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын цалин, урамшууллын хэмжээ, 2024 оны үйл ажиллагааны нийт төсвийг 270,000,000 /Хоёр зуун далан сая/ төгрөгөөр баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд нь хууль болон бусад холбогдох дүрэм, журамд заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, төсвийг үр ашигтай захиран зарцуулахыг үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Д.ОЮУН



МАТЕРИАЛИМПЭКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 26-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

“МАТЕРИАЛ ИМПЕКС КОНСТРАКШН” ХХК-ИЙН ДҮРМИЙГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Материал импекс констракшн” ХХК-ийн “Дүрэм”-ийг Хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. “Материал импекс констракшн” ХХК-ийн гүйцэтгэх захирал Баярын Зориг хэвээр болохыг дурдсугай.
3. Шинэчлэн батлагдсан дүрмийг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн мөрдсүгэй.
4. Энэхүү тогтоол гарсантай холбоотой “Материал импекс констракшн” ХХК-ийн 2016 оны 05 дугаар сарын 02-ны өдөр батлагдсан дүрмийг хүчингүйд тооцсугай.
5. “Материалимпэкс” ХК /хувьцаа эзэмшигчид/-ийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд нь Гүйцэтгэх захирал Баярын Зориг болохыг дурдсугай.

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

№	Үүсгэн байгуулагч хуулийн этгээд	Гарын үсэг, тэмдэг	Үүсгэн байгуулагчийг төлөөлж:
1.	“Материал импэкс” ХК		Гүйцэтгэх захирал, хувьцаа эзэмшигч Б.Зориг
			Хувьцаа эзэмшигч Д.Тунгалаг
			Хувьцаа эзэмшигч Д.Оюун
			Хувьцаа эзэмшигч Д.Төмөр-Очир
			Хувьцаа эзэмшигч Ж.Энхтунгалаг
			Хувьцаа эзэмшигч Б.Ганболд
			Хувьцаа эзэмшигч Ж.Баатар

ХУРЛЫН ДАРГА

Д.ОЮУН

